



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/60.

Биндэр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий
нэгж талбарыг нэгтгэх тухай**

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Банк санхүүгийн зориулалттай, газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий 2 нэгж талбарын газрын хэмжээг хүсэлт гаргасан Төрийн банк /5341469/-ийн эзэмшлийн газрыг хавсралтын дагуу нэгтгэсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг захирамжаар зөвшөөрөгдөж, нэгтгэгдсэн газрын хэмжээгээр олгож, газар эзэмшүүлэх гэрээ байгуулахыг газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Газар эзэмших гэрээний нөхцөл, зориулалтын дагуу газраа эзэмшин, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч (Төрийн банк) 5341469 -д үүрэг болгосугай.


4.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2018 оны А/71, 2026 оны А/41 тоот захирамжуудыг тус тус хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



Сумын Засаг даргын 2026 оны
4 дүгээр сарын 27-ны өдрийн
А/БД захирамжийн хавсралт



№	Газар зэмшигч	Регистрийн дугаар	Нэгтгэж буй нэгж талбарын				Нэгтгэсэн нэгж талбарын					
			Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ /м2/	Байршил	Зориулалт	Хугацаа /жил/	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ /м2/	Байршил	Зориулалт	Хугацаа /жил/
1	Төрийн банк	5341469	2310001540	256	Залуус 1 124	Банк санхүүгийн үйлчилгээ	60		569	Залуус 1 124 тоот	Банк санхүүгийн үйлчилгээ	60
			2310003068	323	Залуус 1 124а	Банк санхүүгийн үйлчилгээ	15					
Нийт								569				